



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

“Эмнэлгийн орчинд унаж бэртэх эрсдэлээс сэргийлэх журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6211:2019, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 12-ны өдрийн А/566 тоот “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай”, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 сарын 05-ны өдрийн А/112 тоот “Журам батлах тухай” тушаал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ-ний 3 дугаар зүйлийн 3.2.7 дахь заалт, 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн орчинд унаж бэртэх эрсдэлээс сэргийлэх журам”-ыг нэгдүгээр, “Унаж бэртэх эрсдэлийн үнэлгээний хуудас”, “Унаж бэртэхээс сэргийлэх хяналтын хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Эмнэлгийн орчинд унаж бэртэх эрсдэлийг бууруулах энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг дэмжлэгт удирдлагаар ханган, чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн хяналт тавьж, гарсан алдаа, зөрчлийг залруулах, дахин зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулахыг Сувилахуйн алба (Ц.Амаржаргал), Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (М.Одсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах эмнэлгийн орчинд унаж бэртэхээс сэргийлэх ээлтэй орчинг бүрдүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллахыг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Б.Түвшинтөр), Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч (О.Баярмаа)-д тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

000410



УЛСЫН НЭГДҮГЭЭР

Тусгай зөвшөөрлийн үйлчилгээний газар

ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ

2024 он

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

БАТАЛГААЖИЛТ

Энэхүү журмыг боловсруулсан, хянасан, баталсан болоод хүчин төгөлдөр байдлыг дараах хүснэгтээр баталгаажуулна.

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ	ОГНОО
БОЛОВСРУУЛСАН	ЭМТҮЧАБА-ны дарга	М.Одсүрэн		
	Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер	Б.Батчимэг		
ХЯНАСАН	Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	Б.Түвшинтөр		


 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

Агуулга

д/д	Гарчиг	Хуудас
1.	Нийтлэг үндэслэл	6
2.	Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх	6-8
3.	Унах эрсдэлийг үнэлэх процесс	8
4.	Унах эрсдэлийг бууруулах арга хэмжээ	8-9
5.	Унаж бэртсэн үед үзүүлэх тусламж	9
6.	Журмын хэрэгжилт	10
7.	Хяналт үнэлгээ, хариуцлага	10
8.	Холбогдох бичиг баримт	10-11
9.	Бусад	11
10.	Унаж бэртэх эрсдэлийг үнэлгээ, хяналтын хуудас	12-13

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал гэдэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах явцад сэргийлж болох гэмтэл учруулахгүй байх явдал юм. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх явцад гэмтэл бэртэл учруулахгүй урьдчилан сэргийлэх нь аюулгүй байдлын үндсэн суурь юм.
- 1.2 ДЭМБ-ын тодорхойлолтоор явганаас унах гэдэг нь гэнэт, хяналтгүй, санаандгүй, зорилгогүйгээр босоо байдлаа алдаж эсвэл юманд тээглэж, тодорхой нэг түвшнээс өөр түвшинд шилжин хий гишгэж шал, шат газар зэрэг гулсамтгай гадаргуу дээр гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр халтирч унах тохиолдол бөгөөд ямар нэгэн зүйл мөргөх буюу газарт унах гэж тодорхойлжээ (Энэ ойлголтод ОУӨвчний ангилал ICD-н W00-W19 оношод хамаарагдах өвчлөл хамаарах бөгөөд ухаан алдаж унах, муужрах эсвэл эпилепси өвчний улмаас татаж унах нь энэхүү ойлголтод хамаарагдахгүй)
- 1.3 Унах эрсдэлийг үнэлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, унах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, уналтаас үүсэх бэртэл гэмтлээс сэргийлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгч, сахиур болон дагалдан яваа үйлчлүүлэгч
- 2.2 Нийт эмч, эмнэлгийн ажилтан, суралцагч нар

Гурав. Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх

- 3.1 Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч, тэдгээрийн ар гэр /сахиур/-ийг унах эрсдэлээс сэргийлэх үнэлгээг тасаг, төв нэгжийн эмнэлзүйн баг /эмч, сувилагч, суралцагч эмч/ унах эрсдэлийн үнэлгээний хуудсаар үнэлнэ /Хавсралт1/

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

3.2 Эмч үйлчлүүлэгчээс асуумж, бодит үзлэгт тулгуурлан унаж бэртэх эрсдэлийг үнэлж цахим өвчний түүхэнд тэмдэглэн, сувилагчид мэдэгдэнэ. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчид шар өнгө бүхий таних тэмдэгтэй бугуйвчийг зүүлгэхдээ:

3.2.1 Асуумжинд тусгасан байх

- Сүүлийн нэг жилийн дотор унаж бэртсэн эсэх
- Явахад саадтай эсэх
- Тэнцвэр алддаг эсэх
- Унах айдастай эсэх
- Эмийн хэрэглээ /сэтгэц нөлөөт бусад/
- Унахад нөлөөлөх архаг болон цочмог эмгэг тодруулах

3.2.2 Бодит үзлэг

- Ухаан санааны байдлыг үнэлэх
- Амин үзүүлэлт /Артерийн даралт, зүрхний цохилтын тоо/
- Харах чадвар тодруулах
- Алхах чадвар

3.3 Сувилагч үйлчлүүлэгчийн унаж бэртэх эрсдэлийг дараах мөчүүдэд

1. Үйлчлүүлэгчийн биеийн байдалд өөрчлөлт орох
2. Тасаг хооронд шилжүүлэх
3. Мэс засал эмчилгээ, ажилбар, оношилгооны дараа
4. Эмийн хэрэглээ нэмэгдэх
5. Ээлж хүлээлцэх бүрт унах эрсдлийн үнэлгээний хуудсын дагуу үнэлж цахим өвчний түүхэнд тэмдэглэл хөтөлнө

3.4 Хэвтэн эмчлүүлэх хэсгийн үйлчлүүлэгчийн унаж бэртэх эрсдэлийн үнэлгээг тасаг, төвийн ахлах, зохицуулах сувилагч хийж үйлчлүүлэгчид шар өнгө бүхий таних тэмдэг зүүлгэж, унаж бэртэх эрсдэлээс сэргийлэх зөвлөмж өгнө. /Хавсралт хуудас 2/

3.5 Унаж бэртэх эрсдэлийн үнэлгээ 25 оноо ба түүнээс дээш тохиолдолд унаж бэртэхээс сэргийлэх хяналтын хуудасны дагуу сувилагч ээлж хүлээлцэж давтан үнэлгээ хийнэ /Хавсралт хуудас 2/


3.6 Тасаг, төвийн эмч, сувилагчийн үйлчлүүлэгчийн унах эрсдэлийн үнэлгээ, хяналтыг сувилахуйн алба өдөр бүр хийж, тасаг төвийн эмч, эрхлэгч нарт болон шаардлагатай тохиолдолд эрсдэлтэй үйлчлүүлэгчийг ЭМТҮЧАБА-ны эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежерт мэдээлэн танилцуулна.

3.7 Эмнэлгийн гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер, хөдөлмөр аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нар тухайн улирал бүр хийж дүгнэлтийг эрсдэлийн удирдлагын багт танилцуулна.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

3.8 Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгчийн унах эрсдэлийг дараах процессын зураглалын дагуу үнэлнэ /Зураг1/

Зураг 1. Унах эрсдэлийг үнэлэх процесс



Дөрөв . Унах эрсдэлийг бууруулах арга хэмжээ

- 4.1. Эмнэлгийн гадаад, дотоод орчныг унах эрсдэлээс сэргийлсэн тохижилтыг сайжруулах /явган хүний зам, шал, шат гишгүүр, хаалга, босго, довжоо, гэрэлтүүлэг, ханын бариул, ариун цэврийн өрөөний нэмэлт бариул, дуудлагын хонх, орны хаалт/
- 4.2. Цэвэрлэгээ хийх болон унах, хальтрах эрсдэлтэй орчин үүссэн тохиолдолд анхааруулга тэмдэг, тэмдэглэгээ байршуулна.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

- 4.3. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчийг шар өнгө бүхий таних тэмдэг /бугуйвч/ зүүх.
- 4.4. Дуслын систем, давсагны гуурс болон бусад төрлийн гуурс, хэрэглэгдэхүүнтэй тохиолдолд ороолцолдохгүй байхаар цэгцлэх.
- 4.5. Эмчлүүлэгчийн орны дэргэд, төв, тасагт унаж бэртэхээс сэргийлэх анхааруулга тэмдэглэгээ заавал байршуулна.
- 4.6. Унах эрсдэл өндөр үйлчлүүлэгч болон ар гэрт сувилагч унаж бэртэхээс сэргийлэх зөвлөмж, эрүүл мэндийн боловсрол олгоно.
- 4.7. Нийт эмнэлгийн ажилтнууд унах эрсдэлтэй үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажиллаж унаж бэртэх эрсдэлийг бууруулан ажиллахад оролцоно.
- 4.8. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх тохиолдолд ашиглах тэргэнцэр, дамнуургын аюулгүй байдлыг шалгаж бэлэн байдлыг хангасан байна.
- 4.9. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх талаар үйлчлүүлэгч болон ар гэрт урьдчилан мэдээлсэн байна.
- 4.10. Үйлчлүүлэгчийг тэргэнцэр, ор луу шилжүүлэхдээ тэргэнцрийн дугуйг түгжинэ.
- 4.11. Тэргэнцэртэй, ортой үйлчлүүлэгчийг цахилгаан шатанд оруулах болон гаргах явцад цахилгаан шатны шал нь талбайн шалтай нэг түвшинд байгаа эсэхийг шалгах.

Тав. Унаж бэртсэн үед үзүүлэх тусламж

- 5.1. Унаж бэртсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэхээс өмнө хөдөлгөхгүй байх, ямар нэгэн ноцтой гэмтэл, бэртэл авсан бол зөөвөрлөхөд тохиромжтой тэргэнцэр эсвэл дамнуургаар зөөвөрлөнө.
- 5.2. Үйлчлүүлэгчийн ухаан санааны байдал, амин үзүүлэлт, өвдөлтийн зэргийг үнэлнэ.
- 5.3. Төв, тасгийн дарга, эрхлэгч, эмч /эмчлэгч, жижүүр / ахлах сувилагчид даруй мэдээлнэ.
- 5.4. Тохиолдол мэдээлэх хуудсаар тухайн үйлчлүүлэгчийн ерөнхий мэдээлэл болон унасан шалтгаан, бэртэл гэмтэл, нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар тэмдэглэж ЭМТҮЧАБА болон Хөдөлмөр аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнд мэдээлнэ.

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

Зургаа. Журмын хэрэгжилт

- 6.1. Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унах эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалтыг тасаг төвийн зохицуулагч сувилагч, Сувилахуйн алба хариуцна.
- 6.2. Чанарын багууд улирал бүр эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежерт мэдээлнэ.
- 6.3. Үйлчлүүлэгчийг унаж бэртэхээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгууллагын хангамжийн алба дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 6.4. Улирал, хагас бүтэн жилийн эцсийн дүгнэлтийг Хөдөлмөр аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер хамтран хийж эрсдэлийн удирдлагын баг, байгууллагын удирдлагын багт тайлагнана.
- 6.5. Журамд оруулсан өөрчлөлтийг өөрчлөлтийн бүртгэлд тэмдэглэнэ.

Долоо. Хяналт үнэлгээ, хариуцлага

- 7.1. Уг журмын хэрэгжилтэнд Сувилахуйн алба хяналт тавина.
- 7.2. Дээрх дурдсанаас гадна журамд тухайн цаг үеийн онцлог болон хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 7.3. Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унаж бэртэхээс сэргийлэх журмыг баримтлаагүй тохиолдолд эрүүл мэндийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу мэдээлэх хуудас бөглөн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албанд мэдээлнэ.

Найм. Холбогдох бичиг баримт

- 8.1. Монгол Улсын хууль тогтоомж Монгол Улсын стандарт “Чанарын менежментийн тогтолцоо- Шаардлага MNS ISO 9001:2016”
- 8.2. Монгол Улсын стандарт “Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга” MNS 6211:2019
- 8.3. УНТЭ-ийн 2022 оны А/135 тоот “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” тушаал
- 8.4. ЭМС-ийн 2019 оны А/566 тоот “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” тушаал
- 8.5. ЭМС-ийн 2024 оны А/112 тоот “Журам батлах тухай” тушаал


 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

- 8.6. ЭМС-ийн 2022 оны А/352 тоот “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам” тушаал
- 8.7. Бусад холбогдох журам, дүрэм заавар

----- 000000 -----

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий
захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний
өдрийн 4/100 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



Унаж бэртэх эрсдэлийг үнэлгээ, хяналтын хуудас

1. Унах эрсдэлийн үнэлгээний хуудас

Эмчлүүлэгчийн овог, нэр:

Нас:

Хүйс: эрэгтэй / эмэгтэй

Өвчний түүх №:

№	Үзүүлэлт	Шалгуур	Оноо
1	Сүүлийн 3 сарын дотор унаж бэртсэн эсэх	Үгүй	0
		Тийм	25
2	2 ба түүнээс дээш хавсарсан эмгэгтэй	Үгүй	0
		Тийм	15
3	Туслах хэрэгсэлтэй эсэх /таяг, алхуулагч, суга таяг гэх мэт/	Үгүй	0
		Тийм	15
4	Эмчилгээнд шаардлагатай нэмэлт гуурстай эсэх /дуслын систем, шээлгүүр гуурс, цээжний хөндий болон хэвлийн хөндийд байрлуулсан гуурс/	Үгүй	0
		Тийм	20
5	Алхах чадвар	Хэвийн /хэвтрийн дэглэм/	0
		Чадвар сул /саажилттай,гэмтэлтэй/	20
6	Ухаан санааны байдал	Хэвийн	0
		Ухаан санаа бүдгэрсэн,өөрчлөлттэй	15
Нийт оноо			

Үнэлгээ хийсэн эмч/сувилагчийн нэр:

Огноо, цаг:

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАЖ БЭРТЭХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024/... /...	Хувилбар 1	Журмын дугаар УНТЭ-ЭМТҮЧАБА- ЭОУБЭСЖ

2. Унаж бэртэхээс сэргийлэх хяналтын хуудас

Эмчлүүлэгчийн овог, нэр:

Нас : Хүйс: эрэгтэй / эмэгтэй

Өвчний түүх №.....

№	Огноо	... сарын ...		
	Үнэлгээ хийсэн цаг	... цаг ... мин	... цаг ... мин	... цаг ... мин
	Унах эрсдэлийн үнэлгээний оноо			
1	Таних тэмдэг зүүж өгөх			
2	Эмчлүүлэгчийн өрөөний гадна анхааруулах тэмдгээ байрлуулах			
3	Байрлал солих болон бие засах зэрэг шаардлагатай тохиолдолд тусламж дуудах зааварчилгаа өгөх			
4	Эмчлүүлэгчийн байнга хэрэглэдэг зүйлсийг гарт нь ойр байлгах			
5	Шал нойтон үед арчиж цэвэрлэх			
6	Орчны гэрэлтүүлгийг хангалттай байлгах			
7	Эмчлүүлэгч орон дээр байгаа үед орны хашлагыг өндөрлөх			
8	Орны өндөр нам тохируулах			
9	Үйлчлүүлэгч тохирсон нүдний шил, сонсголын аппарат ашиглах			
10	Эмчлүүлэгч болон ар гэрт унахаас сэргийлэх арга хэмжээг тайлбарлан хамтран ажиллах			
11	Тэргэнцэр болон таяг зэргээр хангах			
12	Тусламж үйлчилгээг гараас гарт гэсэн зарчмаар явуулах			
13	Хөлд эвтэйхэн, халтирдаггүй ултай гутал өмсөх			
14	Шалан дээр тээглэх зүйлс байгаа эсэхийг анхаарах			
15	Эмчлүүлэгчийн орны дэргэдэх орчны аюулгүй байдлыг хангах			
	Хянасан сувилагч			
	Ахлах сувилагч			

Үнэлгээ хийсэн эмч/сувилагчийн нэр:

.....

Огноо, цаг:

.....